

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 дугаар сарын 17

№ 01

Улаанбаатар хот

*“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг зарлан хуралдуулах тухай”*

Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 69.3, 69.6, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2.1, 2.3, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ыг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Товер, 6 давхар, Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байр хаягт хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - Нэг.** Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - Хоёр.** Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - Гурав.** Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
  - Дөрөв.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. ХЭЭХ-г хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 8-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал зохион байгуулах комисст дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай:
  - i. Гүйцэтгэх захирал Я.Нэргүй

- ii. Хуульч А.Солонго
- iii. Хуульч Э.Анударь

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-н дагуу баталж, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, бүртгэл, хаяг нь тодорхой хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын хүрээнд Компанийн хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгүүдийн жагсаалтыг, эдгээр баримт бичгийг бэлэн болгох боломжтой хугацааны хамт Хавсралт №2-р тогтоож, ажлын өдрүүдэд 09:00 цагаас 18:00 цагийн хооронд Компанийн байранд хүрэлцэн ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Я.Нэргүй, Тооллогын комиссын даргаар А.Солонго, гишүүнээр Э.Анударь нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №3-р баталсугай.
10. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2025 оны 04 дүгээр сарын 8-ны өдрийн ҮЦТХТ ХХК-ийн бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн Хавсралт №4-р баталсугай.
11. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Хавсралт №5,6-р баталсугай.
12. Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу саналын хуудсаар санал өгч болох бөгөөд ийнхүү санал өгөх сүүлийн хугацаа нь 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цаг хүртэл байна. Саналын хуудасны загварыг Хавсралт №7,8-р баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 дугаар сарын 17

№ 02

Улаанбаатар хот

*“Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн  
талаарх дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн  
хуралд танилцуулж, батлуулах тухай”*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Д.ГОНГОР